



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Тариат сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/84/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор П.Энхжаргал Утас: 99743112 Цахим хаяг: enkhjargalp@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Албан шаардлага	13
4.2 Зөвлөмж.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



ТАРИАТ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГА А.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

᠒᠐22.02.22 № 51
танай _____ -ны № _____ -г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тариат сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Тариат сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.


Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,158,550.00	14,158,550.00
35	БАРАА МАТЕРИАЛ	14,158,550.00	14,158,550.00
35100	Түүхий эд материал	6,112,985.00	6,112,985.00
35110	Тусгай зориулалттай материал	6,112,985.00	6,112,985.00
35400	Хангамжийн материал	8,045,565.00	8,045,565.00
35410	Бичиг хэргийн материал	975,440.00	975,440.00
35420	Аж ахуйн материал	5,032,625.00	5,032,625.00
35450	Барилгын засварын материал	2,037,500.00	2,037,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	716,427,259.83	710,047,399.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	716,427,259.83	710,047,399.75
39200	Биет хөрөнгө	710,522,259.83	704,142,399.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	733,615,944.60	733,615,944.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	-40,756,441.44	-52,983,373.80
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	24,476,960.00	34,846,010.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,195,293.42	-21,920,376.74
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,000,000.80	13,400,000.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,066,938.71	-12,330,133.11
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	305,295.00	305,295.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,515,544.00	3,515,544.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,515,544.00	-3,515,544.00
39217	Ном	9,142,733.00	9,209,033.00
39300	Биет бус хөрөнгө	5,905,000.00	5,905,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,905,000.00	5,905,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	730,585,809.83	724,205,949.75
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,931,290.00	15,085,642.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,931,290.00	15,085,642.00
41300	Өглөг	9,931,290.00	15,085,642.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	5,154,352.00
41360	Бусад өглөг	9,931,290.00	9,931,290.00
41361	Байгууллагад төлөх өглөг	9,931,290.00	9,931,290.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	720,654,519.83	709,120,307.75
51	Засгийн газрын хувь оролцоо	720,654,519.83	709,120,307.75
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	98,342,352.80	98,342,352.80
51200	Хуримтлагдсан үр дүн	-124,784,255.26	-136,318,467.34
51210	Өмнөх үеийн үр дүн	-105,160,523.44	-124,784,255.26
51220	Тайлант үеийн үр дүн	-19,623,731.82	-11,534,212.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	747,096,422.29	747,096,422.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	730,585,809.83	724,205,949.75

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	98,479,400.00	107,337,250.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,600,000.00	8,346,550.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,600,000.00	8,346,550.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,600,000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,600,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	8,346,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	94,879,400.00	98,990,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	94,879,400.00	98,990,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,879,400.00	98,990,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	118,103,131.82	118,871,462.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	118,103,131.82	118,871,462.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	117,205,708.82	117,951,415.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,914,299.00	64,414,300.00
210101	Үндсэн цалин	60,914,299.00	64,414,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,629,190.00	8,353,265.00
210201	Тэтгэврийн даатгал	5,192,690.00	5,796,723.00
210202	Тэтгэмжийн даатгал	609,100.00	639,142.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	487,300.00	511,306.00
210204	Ажилгүйдлийн даатгал	121,800.00	127,820.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,218,300.00	1,278,274.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,239,311.00	27,054,352.00
210301	Гэрэл, цахилгаан	939,582.00	1,134,640.00
210302	Түлш, халаалт	24,299,729.00	25,919,712.00
2104	Хангамж, бараа материалын зардал	656,800.00	591,800.00
210401	Бичиг хэрэг	66,500.00	66,500.00
210402	Тээвэр, шатахуун	352,000.00	352,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	70,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	168,300.00	103,300.00
2105	Нормативт зардал	0.00	65,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	65,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00
2107	Томилолт, зочны зардал	70,600.00	70,600.00
210702	Дотоод албан томилолт	70,600.00	70,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	222,288.00	86,888.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	142,288.00	20,888.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,373,220.82	17,215,210.08
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,373,220.82	17,215,210.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	897,423.00	920,047.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	438,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	438,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	597,423.00	481,247.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	597,423.00	481,247.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-19,623,731.82	-11,534,212.08
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-19,623,731.82	-11,534,212.08

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,342,352.80	747,096,422.29	-105,160,523.44	740,278,251.65
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	98,342,352.80	747,096,422.29	-105,160,523.44	740,278,251.65
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-19,623,731.82	-19,623,731.82
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,342,352.80	747,096,422.29	-124,784,255.26	720,654,519.83
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	98,342,352.80	747,096,422.29	-124,784,255.26	720,654,519.83
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	98,342,352.80	747,096,422.29	-124,784,255.26	720,654,519.83
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-11,534,212.08	-11,534,212.08
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	98,342,352.80	747,096,422.29	-136,318,467.34	709,120,307.75

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	94,879,400.00	98,990,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	94,879,400.00	98,990,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	94,879,400.00	98,990,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,879,400.00	98,990,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	93,313,100.00	96,501,900.00

21	УРСГАЛ ЗАРДАЛ	93,313,100.00	96,501,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,415,677.00	95,581,853.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,914,299.00	64,414,300.00
210101	Үндсэн цалин	60,914,299.00	64,414,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,629,190.00	8,353,265.00
210201	Тэтгэврийн даатгал	5,192,690.00	5,796,723.00
210202	Тэтгэмжийн даатгал	609,100.00	639,142.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	487,300.00	511,306.00
210204	Ажилгүйдлийн даатгал	121,800.00	127,820.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,218,300.00	1,278,274.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,900,000.00	21,900,000.00
210301	Гэрэл, цахилгаан	939,582.00	1,134,640.00
210302	Түлш, халаалт	20,960,418.00	20,765,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал	607,800.00	607,800.00
210401	Бичиг хэрэг	66,500.00	66,500.00
210402	Тээвэр, шатахуун	352,000.00	352,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	70,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300.00	119,300.00
2105	Нормативт зардал	49,000.00	49,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.00	49,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00
2107	Томилолт, зочны зардал	70,600.00	70,600.00
210702	Дотоод албан томилолт	70,600.00	70,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,144,788.00	86,888.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	922,500.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	142,288.00	20,888.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	897,423.00	920,047.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	438,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	438,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	597,423.00	481,247.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	597,423.00	481,247.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,566,300.00	2,488,800.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,566,300.00	2,488,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,566,300.00	2,488,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,566,300.00	2,488,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,566,300.00	2,488,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,566,300.00	-2,488,800.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	98,990,700.00	98,509,453.00	481,247.00	99.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,990,700.00	98,509,453.00	481,247.00	99.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	98,551,900.00	98,070,653.00	481,247.00	99.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,414,300.00	64,414,300.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	64,414,300.00	64,414,300.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,695,900.00	8,353,265.00	342,635.00	96.06
210201	Тэтгэврийн даатгал	6,119,400.00	5,796,723.00	322,677.00	94.73
210202	Тэтгэмжийн даатгал	644,100.00	639,142.00	4,958.00	99.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	515,300.00	511,306.00	3,994.00	99.22
210204	Ажилгүйдлийн даатгал	128,800.00	127,820.00	980.00	99.24
210205	Эрүүл мэндийн даатгал	1,288,300.00	1,278,274.00	10,026.00	99.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,900,000.00	21,900,000.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,700,000.00	1,134,640.00	565,360.00	66.74
210302	Түлш, халаалт	20,100,000.00	20,765,360.00	-665,360.00	103.31
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	0.00	100,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	674,100.00	674,100.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	66,500.00	66,500.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	352,000.00	352,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	70,000.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	66,300.00	66,300.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300.00	119,300.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	49,000.00	49,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.00	49,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	70,600.00	70,600.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	70,600.00	70,600.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,648,000.00	2,509,388.00	138,612.00	94.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,422,500.00	2,422,500.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	66,000.00	14,000.00	82.50
210807	Газрын төлбөр	145,500.00	20,888.00	124,612.00	14.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	438,800.00	438,800.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	438,800.00	438,800.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	438,800.00	438,800.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	98,990,700.00	98,509,453.00	481,247.00	99.51
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	98,990,700.00	98,509,453.00	481,247.00	99.51
320001	Орон нутгийн төсвөөс	98,990,700.00	98,509,453.00	481,247.00	99.51
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	6		100.00
620001	Удирдах ажилтан	1	1		100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4		100.00
620003	Үйлчлэх ажилтан	1	1		100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Тариат сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тариат сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Тариат сумын Соёлын төв нь ард иргэдэд соёл урлаг, олон нийтийн арга хэмжээг зөв боловсон хүргэж, хүүхэд залуучуудын авъяас билгийг нээн илрүүлж, олныг хүртээл болгох мөн соёлын үйлчилгээний цар хүрээг өргөтгөж соёлын стандартын шаардлагыг хангах зорилготой соёл урлагын үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн төсвөөс санхүүждэг, төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “Соёл урлагийн хүртээмжтэй олон талт үйлчилгээг нийгэмд хүргэж чадахуйц өрсөлдөх чадвар бүхий, тогтвортой, хариуцлагатай, үр ашигтай орон нутгийн онцлог шинжийг харуулсан соёл урлагийн үйлчилгээг хүргэх” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Соёлын тухай хуульд 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр өөрчлөлт орсон байна. Харин санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагаанд дотоод хяналтын нэгжээс санхүүгийн

гүйлгээ, шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулсан талаар, няравын тайлан, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын талаар нийт 3 чиглэлээр дотоод хяналт шалгалтыг үүрэг даалгавар өгч ажилласан байна.

Тариат сумын Соёлын төв нь Архангай аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/841 дүгээр тушаалаар батлагдсан Соёлын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд бусад эрх бүхий байгууллагаас болон хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Тариат сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 98.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 0.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 6.4 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	14.2	14.2	0	0.0
Үндсэн хөрөнгө	716.4	710	-6.4	-0.9
Нийт хөрөнгө	730.6	724.2	-6.4	-0.9
Өр төлбөр	9.9	15.1	5.2	52.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	720.7	709.1	-11.6	-1.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	730.6	724.2	-6.4	-0.9

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос өөрчлөлт ороогүй байна.

Бараа материалын данс нь 14.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 0.7 төгрөг нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 0.7 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 14.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 0.9 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 716.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 2.5 сая төгрөгөөр, БСШУЯ-наас үнэ төлбөргүй хүлээн авсан 8.3 сая төгрөг нийт 10.8 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 17.2 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, 710.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 52.5 хувиар өссөн байна.

Өр төлбөр данс нь 9.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд 5.2 сая төгрөгөөр нэмэгдэж эцсийн үлдэгдэл 15.1 сая төгрөг болсон байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 11.6 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/ сая.төгрөг /

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	94.9	99.0	4.1
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	3.6	8.3	4.7
Үйл ажиллагааны орлого	98.5	107.3	8.8
Цалин, шимтгэлийн зардал	60.9	64.4	3.5
Бусад бараа үйлчилгээний зардал	34.6	37.2	2.6
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.2	0.1	-0.1
Бараа үйлчилгээний бусад зардал	22.4	17.1	-5.3
Үйл ажиллагааны зардал	118.1	118.8	0.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-19.6	-11.5	8.1

Тариат сумын Соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 4.1 сая төгрөгөөр буюу 4.3 хувиар өссөн нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд 2021 онд батлагдсан зардлыг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 108.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 9.9 сая төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 98.9 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 98.9 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 98.9 сая төгрөгийн орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 98.5 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан, 0.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 0.3 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 0.1 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус соёлын төв нь 2021 онд шинээр батлагдсан Ковид-19 цар тахлын үед улс, аймаг сумын онцгой комиссоос аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгааны дагуу соёл урлагийн үйлчилгээг хориглосны улмаас соёл урлагийн болон олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 93.0 хувьтай байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

- Албан хаагчдын үр дүнгийн урамшуулалд 15.1 сая төгрөг, албан томилолтын зардалд 0.07 сая төгрөг, бусад тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд батлагдсан төсвөөс 0.5 сая төгрөгийг төвлөрүүлэн 1.9 хувийг хэмнэж, 8.1 хувийн буюу 2.1 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.
- Суудлын автомашингүй.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэл байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлжээ.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Архангай аймгийн Тариат сумын соёлын төв нь 2021 онд нийт 20.7 сая төгрөгийн 135 мэдээлэхээс 134 мэдээллийг хугацаанд нь ил тод мэдээлсэн хэдий ч 1 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаа хоцроон байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах **зөвлөмжийг** хүргүүлжээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд батлагдсан төсвөөс 0.5 сая төгрөгийг төвлөрүүлэн 1.9 хувийг хэмнэж, 8.1 хувийн буюу 2.1 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлжээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн твшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, тухай байгууллагаас шалтгаалаагүй санхүүжилт дутуу батлагдаж ирсэнтэй холбоотой түлш халаалтын өр төлбөр үүссэн 15.1 сая төгрөг, төсвийн хэмнэлттэй холбоотой 2.1 сая төгрөг, дрон худалдан авсан 2.4 сая төгрөгийн зөрчлүүдийг материаллаг бус гэж үнэлэн Зөрчилгүй дүгнэлт хүргүүлээ.

4.1 Албан шаардлага

- Тайлант онд Юу Эф Өү Дрийм ХХК-иас 2.4 сая төгрөгийн дрон худалдан авсан байна. Энэ нь Энэ нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн тухай авах зарим арга хэмжээ"-ний 1.4 "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад.....албан конторын тавилга, тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалтыг зөрчсөн байна.

Энэ нь Төсвийг хэмнэлтийн Засгийн газрын 43 дугаар тогтоол болон Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

4.2 Зөвлөмж

- Тайлант онд түлш халаалтын 15.1 сая төгрөгийн өр төлбөртэй ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар							
1	Тариат сумын Соёлын төв	1	15.1			1	15.1
Дүн		1	15.1			1	15.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал							
1	Тариат сумын Соёлын төв	3	4.6	2	4.6	1	0
Дүн		3	4.6	2	4.6	1	0
Нийт дүн		4	19.7	3	19.7	1	15.1